



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 16 өдөр

Дугаар А/150

Мандалговь

Малд үзлэг, ангилалт хийх
баталгаажуулах тухай

Малын генетик нөөцийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.3 дахь заалт, Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн А-45 тоот тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Өндөршил сумын “Өндөршил” омгийн адуу, Сайнцагаан сумын “Сайнцагаан” омгийн хонь, Хулд сумын “Олдохын хүрэн бор” омгийн тэмээ, Эрдэнэдалай сумын нутгийн монгол хонь, Баянжаргалан сумын нутгийн монгол үхэр сүрэгт үзлэг ангилалт хийж, хээлтүүлэгч шинээр нөхөн тавих, баталгаажуулах, цөм сүрэг бүрдүүлэх малын тоог нэгдүгээр хавсралтаар, орон нутагт зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий ажлын хэсгийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Малд үзлэг ангилалт хийх баталгаажуулах ажлыг 2021 оны 04 дүгээр сарын 01-нээс 2021 оны 11 дүгээр сарын 15-ны дотор зохион байгуулж тайланг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт хүргүүлэхийг холбогдох сумдын Засаг дарга нарт даалгасугай.

3.Тухайн ажлыг технологит хугацаанд үр дүнтэй зохион байгуулж, цөм сүрэг бүрдүүлэх, стандартын шаардлага хангасан үржлийн малыг ээмэгжүүлж бүртгэлжүүлэх, хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүй удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар (Б.Мөнхжаргал)-д, биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481210420